



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#5 (14)

2023 он

V сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ХАМТЫН САНААЧИЛГА, ТҮНШЛЭЛ-2023” ҮНДЭСНИЙ ЭВЭНТ “ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨХ ӨНӨӨДРИЙН ДУУДЛАГА” ЧУУЛГАНД ХҮҮХДҮҮД ДУУ ХООЛОЙГОО ӨРГӨН МАНЛАЙЛЛАА.



Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэйгээр 2020-2023 онд хэрэгжсэн “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ-II” төслийн “Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл-2023” сэдэвт үндэсний нэгдсэн арга хэмжээ “ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨХ ӨНӨӨДРИЙН ДУУДЛАГА: ӨСВӨР ҮЕИЙНХЭН” нэртэйгээр чуулганыг зохион байгууллаа.



Чуулга уулзалтад ТХБ-II төслийг хэрэгжүүлж буй 6 аймаг, нийслэлийн 2 дүүргийн загвар 30 сургуулийн удирдах ажилтан, багш, сурагч, төслийн сонгогдсон төлөөлөл, олон улсын хандивлагч байгууллага, хувийн сектор, БШУЯ, БОАЖЯ зэрэг салбар яам, төрийн байгууллагын төлөөлөл, нийт 350 гаруй хүн оролцлоо.

Чуулганд “Тогтвортой хөгжлийн боловсрол-2030; Монгол Улсын санаачилга”-ын богино хугацаа (2025 он хүртэл)-ны товлосон зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нарийвчилсан саналыг тусгах зорилгоор 5 салбар хуралдаан зохион байгуулав.



Салбар хуралдаанаар ЮНЕСКО-оос удирдамж болгосон Замын зураглалыг баримтлан бодлогыг уялдуулах, суралцахуйн орчныг хувирган өөрчлөх, сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулах, залуучуудад боломж, эрх мэдэл олгох, орон нутгийн түвшний үйлийг хурдасгах гэсэн үйлийн тэргүүлэх таван чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх гол үйл ажиллагааг ялган, хариуцан гүйцэтгэх байгууллага, хугацаа, хүрэх гол үр дүнг тодорхойлох дадлага ажил хийгдсэн.



“СӨБ болон ерөнхий боловсролын сургалтын шинэ хөтөлбөрийн үзэл баримтлалын бүтцийг танилцуулах” хэлэлцүүлэг



СӨБ болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үзэл баримтлалыг танилцуулах, оролцогчид нэгдсэн ойлголттой болох зорилготой хэлэлцүүлэг 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Улаанбаатар зочид буудал, Сонгинохайрхан танхимд Боловсролын судалгааны


үндэсний хүрээлэн UNICEF олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулагдлаа.

БШУЯ-ны харьяа мэргэжлийн байгууллагууд болох Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын мэдээлэл технологийн төв, Нийслэлийн боловсролын газрын төлөөллүүд нийт 50 гаруй хүн оролцов.



"Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах" сургалт 1

ЮНЕСКО-ийн Олон Улсын Боловсролын Товчооноос Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж буй "Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах" 4 өдрийн сургалт цахимаар явагдаж эхэллээ.



ЮНЕСКО-гийн Олон улсын боловсролын товчоо, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран зохион байгуулсан СӨБ болон ЕБС-ийн сургалтын шинэ хөтөлбөр боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах зорилготой сургалт 2023 оны 5 дугаар сарын 3,4, 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулав.

Сургалтад БСҮХ-ийн СХҮСБСС-ын эрдэм шинжилгээний ажилтнууд, БЕГ-ын сургалтын хөтөлбөр, багшийн хөгжил хариуцсан мэргэжилтнүүд, БҮТ-ийн мэргэжилтнүүд, Их дээд сургуулийн багш нар, ЕБС-ийн багш нараас бүрдсэн нийт 190 хүн оролцсон байна.

"Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах" сургалт 2

СӨБ болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах сургалт 5 судлагдахууны чиглэлээр 2023 оны 05 дугаар сарын 22-оос зохион байгуулагдаж эхэллээ. Энэхүү сургалтыг Кембрижийн 5 сургагч багш нартай БСҮХ хамтран зохион байгуулж байна. Сургалтад БСҮХ, БЕГ, БҮТ, БМТТ, МУИС, МУБИС, СӨББ, ЕБС, төрийн бус байгууллагын төлөөлөл 100 гаруй хүн оролцсон байна.



СӨБ болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах сургалт 3 дахь өдрөө үргэлжилж байна.

Сургалтаар

- Сургалтын хөтөлбөрийн дизайн, зарчим
- Сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо
- Сургалтын хөтөлбөрийн нэгжүүд
- Тэнцвэртэй сургалтын хөтөлбөр
- Суралцахууд чиглэсэн төлөвлөлт багшлахуй
- Багшлахуйн чиг хандлага

Судлагдахууны интеграци ба бүтэц гэсэн чиглэлээр хэлэлцлээ.



ОНОЛ ПРАКТИКИЙН БАГА ХУРАЛД

Монголын улаан загалмайн нийгэмлэг, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнтэй хамтарсан “Гамшгаас хамгаалах сургалтын өнөөгийн байдал, хүртээмж, үр нөлөө” сэдэвт онол практикийн бага хуралд БСҮХ-ийн Боловсролын Хөгжлийн Ирээдүй Судлалын Судалгааны секторын ЭШ Ажилчид, “Байгалийн гамшигт үзэгдэл зудын үеийн боловсрол” сэдвийн хүрээнд зудтай хэмээн бүртгэгдсэн 4 бүсийн алслагдсан 19 сумын сургуулиудаас авсан судалгааны үр дүнг танилцууллаа.



“ХУВЬСАЖ БУЙ БОЛОВСРОЛ” ОЛОН УЛСЫН ХУРАЛД

“Дээд боловсролын чанарын баталгаажуулалт: Хувьсаж буй боловсрол” Олон Улсын эрдэм шинжилгээний хурал МУБИС дээр зохион байгуулагдлаа. Энэ хурлын “Шинэ үеийн багш- багшлахуй” салбар хуралдаанд “Ирээдүйн боловсрол дахь багшийн чиг үүрэг баримт бичгийн шинжилгээний зарим үр дүн” илтгэлийг хэлэлцүүлээ.

Ирээдүйн боловсрол дахь багшийн гүйцэтгэх үүрэг хэрхэн өөрчлөгдөж байгаа чиг хандлагыг илрүүлэх зорилгоор ЮНЕСКО-гоос гаргасан бодлогын баримт бичиг болон судалгааны тайлангуудад тусгагдсан багшийн чиг үүрэгтэй холбоотой хэсгүүдэд шинжилгээ хийсэн болно. Шинжилгээний үр дүнд ирээдүйн багш 7 чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж үзсэн байна.

“ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫН ХЭРЭГЦЭЭ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА”-НЫ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ УУЛЗАЛТ



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр “Иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ тодорхойлох судалгаа”-г амжилттай хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны үр дүнгээ өнөөдөр НҮБХХ, БШУЯ болон түүний харьяа байгууллага, ЦХХХЯ, И-Монгол академи зэрэг байгууллагуудын арга зүйч, мэргэжилтнүүдэд танилцууллаа.

“ЭХ ХЭЛ ДЭЭР СУУРИЛСАН ОЛОН ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ: ӨНӨӨГИЙН АСУУДАЛ, ШИЙДЭЛ” БҮСИЙН СУРГАЛТ



Европын Аюулгүй байдлын Хамтын Ажиллагааны байгууллагын Үндэстний цөөнхийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын Төв Азийн боловсролын хөтөлбөр төслийн хүрээнд “Эх хэл дээр суурилсан олон хэлний боловсрол: өнөөгийн асуудал, шийдэл” сэдэвт уламжлалт 10 дахь удаагийн сургалт Казахстан улсын Алматы хотод зохион байгуулагдлаа.

Сургалтад Казахстан, Кыргызстан, Узбекистан, Тажикстан, Туркменистан, Молдав, Гүрж, Монгол зэрэг улс орны төлөөллүүдийн хамт, Эстони, Латви, Америк, Италийн олон улсын шинжээчид зочноор оролцов.



Монгол улс 4 дэх удаагаа оролцож байгаа тус сургалтад Боловсролын Ерөнхий газрын мэргэжилтэн, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд оролцов.

Сургалтад оролцсон улс орнууд олон хэлний боловсролын чиглэлээр өөрийн улс орныхоо сайн туршлагаасаа хуваалцаж, асуудлаа хамтран шийдэх боломжуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлэв. ЕАБХАБ-ын төлөөлөгч улс орнуудын цаашид хийх ажлын төлөвлөгөөг

сонсож, төлөөллүүд хамтран олон хэлний сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэлийн баримт бичгийн загварыг гаргав. Улс орнуудын хамтын ажиллагааг улам бэхжүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.

“ЭЭРЭГ ХАНДЛАГА” БТСУХ-НЫ ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ

Сургалтаар “Тэгш хамруулах боловсролын орчин үеийн чиг хандлага” сэдвээр хичээл заасан. ХБХЕГ дээр сургалт, семинарт санал солилцох уулзалтад оролцсон.

“Монгол дохионы хэл” сургалтын хөтөлбөрийн суралцахуйн удирдамж боловсруулах ажлын хэсгийн уулзалт, сайжруулалт дээр ажиллаж байна.

“Багшийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт ба хүүхдийн эрх, хамгааллын харилцан хамаарал, асуудал-шийдэл”

Тэгш хамруулах боловсрол судалгааны хүрээнд нийслэлийн БЗД-ийн 88-р сургууль, Хан-Уул дүүргийн 118, 15 дугаар сургууль, Сүхбаатар дүүргийн 71, 58 дугаар сургууль, 25-р сургууль, Архангай, Увс, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн зорилтот ерөнхий боловсролын сургуулийг хамруулан нийт 18 сургуулиас цуглуулсан мэдээллийг нэгтгэн, үр дүнд шинжилгээ хийв.

Судалгааны тайлангийн төсөл боловсруулан эхний хэлэлцүүлгийг БШУЯ-нд 05.23-ний өдөр зохин байгуулан, эхний үр дүнг танилцуулав.

Туршилт судалгааны мэдээлэл цуглуулж үр дүнг боловсрууллаа.



Тусгай хэрэгцээт боловсролын хүүхдийн хөгжлийн онцлогийн судалгааны арга зүйн тохирцыг үнэлэх туршилт судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Ерөнхий боловсролын 3 сургууль дээр гүйцэтгэж, үр дүнг боловсруулсан нь Хүний хөгжлийн судалгааны секторын 5 сарын онцлох ажил байлаа.

“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих нь” төслийн судалгааны мэдээлэл цуглуулах ажлын бүрэлдэхүүн орж ажиллан судалгааны мэдээллийг боловсруулан мэдээллийн сан үүсгэх, тайлан боловсруулж, хэлэлцүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

Секторын ЭША Б.Баярмаа хүрээлэнгээс хэрэгжүүлсэн “Иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ тодорхойлох түүвэр судалгаа”-ны эцсийн тайлан орчуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгалийн ухааны цахим сургалтын хөтөлбөрийг турших үйл ажиллагаа



БСҮХ, БҮТ хамтарч Байгалийн ухааны цахим хөтөлбөрийг турших 50 сургууль болон хяналтын сургуулийн сурагчдаас барианы шалгалтыг зохион байгуулав. Туршилтын 17 сургуулийн 640 сурагч, хяналтын 14 сургуулийн 631 сурагч хамрагдсан бөгөөд барианы үнэлгээний үр дүнг боловсруулах ажил хийгдэж байна.

Багшийн сэтгэл ханамжийн судалгаа

Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж буй багш нарын сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг боловсруулан, асуулгыг авч мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Түвшин бүрээр багшийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг гаргаж нэгтгэн БШУЯ-д хүргүүлэн ажиллаж тайлагнав.

“Мэдлэг туршлагаа солилцох” өдөрлөгийг “Монгол дахь Австралид төгсөгчдийн холбоо”-той хамтран зохион байгууллаа.



Монгол Улсын Засгийн газраас 2021 онд баталсан “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ батлах тухай” 372 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн “Мэдлэг туршлагаа солилцох” өдөрлөгийг “Монгол дахь Австралид төгсөгчдийн холбоо”-той хамтран 05-р сарын 24-нд танхим, цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.

Энэхүү өдөрлөгт Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, БСҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга

С.Санжаабадам, Улаанбаатар дахь Бритиш сургуулийн захирал Mark Reed Улаанбаатар дахь Бритиш сургуулийн үйл ажиллагаа хариуцсан захирал Г.Энхцэцэг, Монгол дахь Австралид төгсөгчдийн холбоо – Монгол Австралийн нийгэмлэгийн ерөнхий захирал Л.Ариунаа, АНУ-ын Элчин сайдын яамны англи хэлний хөтөлбөрийн мэргэжилтэн Т.Алтанцэцэг, Англи Хэлний Институтийн Монгол дахь салбар төлөөлөгчийн газрын захирал Крэг Портэл, Энхтайваны корпусын сайн дурын мэргэжилтэн Л.Даниел, Лингорс боловсролын байгууллагын хамтын ажиллагаа хариуцсан захирал С.Хурц, Гүрэн академийн гүйцэтгэх захирал Б.Даваасүрэн нар уригдан оролцов.




Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3-р сургуулийн Зөвлөгч сурагч хөтөлбөрийн анги хамт олон Б.Цэрэннадмид багшийн хамтаар зорин ирж оролцсоноос гадна Англи хэлний Велком, Зөвлөгч сурагч тэтгэлэгт хөтөлбөрүүдийн оролцогчид багш нар, Гүрэн академийн Астрид төсөлд хамрагдагч багш суралцагчид, МУБИС-ийн TESOL сургалт, Зөв тусгал ТББ - Канадын конкордиа коллежийн TESOL дипломын сургалт, Англи хэлний институтийн EXCEL хөтөлбөр, АНУ-ын Пиннакл академийн англи хэлний багшийг чадавхжуулах хөтөлбөрүүд, Английн Пийрсон боловсролын байгууллагын төсөлд хамрагдаж байгаа сургуулиуд, Лингорс боловсролын байгууллагын англи хэлний сургалтын оролцогчид, багш нар, суралцагчдын төлөөлөл танхимаар болон цахимаар тус арга хэмжээнд оролцож энэ хичээлийн жилд хүрсэн ололт амжилтаа хамтдаа тэмдэглэлээ. Үүнд:



1. Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн Гадаад хэлний төв, Боловсролын ерөнхий газар, Улаанбаатар хот дахь “Бритиш сургууль”-тай хамтран энэ оны 02 дугаар сарын 11-аас 05 дугаар сарын 10-ний өдрийн хооронд ЕБС-ийн 30 багшийг сургасан сургагч багш бэлтгэх дунд хугацааны хөтөлбөрийн батламж гардуулах, хаалтын үйл ажиллагаа
2. “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу Ахлах ангийн сурагчдад зориулсан англи хэлний нэг жилийн эрчимжүүлсэн “WELCOME”, “ЗӨВЛӨГЧ СУРАГЧ” хөтөлбөрийн батламж гардуулах үйл ажиллагаа
3. БСҮХ, Гадаад хэлний төвөөс хэрэгжүүлж буй Pinnacle, Зөвлөгч сурагч болон Вэлком хөтөлбөрийн багш сурагчдын төлөөлөл сурсан мэдсэнээ бусадтайгаа хуваалцаж мэдлэг мэдээлэл солилцов.
4. Монгол дахь Австралид төгсөгчдийн /Mozzies/ холбооны гишүүн, Интермэд эмнэлгийн Эмнэлгийн мэргэжилтний албаны дарга Д.Энхтуяа хүрэлцэн ирж “Хувь хүний хөгжил”-ийн талаар сургалт зохион байгуулсан.

Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан “Орчин цагийн Монгол хэлний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь” эрдэм шинжилгээний хуралд

2023 оны 05 сарын 20, 21-нд Япон улсын Токио хотноо “Орчин цагийн монгол хэл бүрэлдэн тогтсон нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Шова Эмэгтэйчүүдийн Их Сургууль дээр амжилттай зохион байгууллаа.



Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Япон улсын Шова Эмэгтэйчүүдийн их сургууль, Монгол хэл шинжлэлийн нийгэмлэг Тус хуралд Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль, Сэйсон Жогакүин Их Сургууль, Айчи Шүкүтокү Их Сургууль, Шова Эмэгтэйчүүдийн Их Сургууль болон Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, МУИС, МУБИС, ОУУБИС, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Плехановын их сургуулийн эрдэмтэн судлаачид оролцож хэлний бодлого, хэл эзэмшихүй, бичиг үсэг судлал, нэр томьёо судлал, компьютер

хэл шинжлэл, үгийн сан, утга судлал, хэлзүй, харьцуулсан, зэрэгцүүлсэн хэл шинжлэл, нутгийн аялгуу судлалын чиглэлээр нийт 16 илтгэл хэлэлцүүлээ.

Монгол улсын эрдэмтдээс гадна гадаадын монгол судлаачид үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон туршлага, өнөөгийн байдал, цаашдын хандлагын талаар буюу тодорхой нэгэн сэдвийн хүрээнд санал онолоо солилцож судалгааны үр дүнгээ хэлэлцсэнээрээ энэхүү хурлын онцлог оршиж байна. БСҮХ-ийн МХБСАТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Гэрэлмаа “Хүүхдийн академик үгийн сангийн нөөц ба түвшнийг тогтоох нь” судалгааны эхний 2 үе шатны үр дүнг танилцуулсан байна. Үүнд сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөр сурах бичгийн хөмрөгт хийсэн шинжилгээний үр дүн, гадаадын 8 хэлний А түвшний үгийн жагсаалтыг хооронд нь болон монгол хэлний хөмрөгтэй харьцуулж шинжилгээ хийсэн үр дүнг хэлэлцүүлэв.